

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
БАТАЛСАН ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТАД ХИЙСЭН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2024 оны 04 дүгээр сарын 17

Улаанбаатар хот

Д/д	Тушаалыг			Актын утга	Улсын нэгдсэн бүртгэлийн дугаар	Захиргааны хэм хэмжээний актын		
	Баталсан албан тушаалтан	Огноо	№			Хэрэгжилт	Үнэлгээ	Санал
1	Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар	2010.12.08	№А/396	<p>Журам батлах тухай</p> <p>“Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэх хүсэлт гаргасан гадаадын иргэнтэй ярилцлага хийх тухай журам”-ыг нэгдүгээр, ярилцлага хийх комиссын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар</p>	3224	<p>Үндэслэл: Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.2-д “Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэх хүсэлт гаргасан гадаадын иргэнтэй ярилцлага хийх журмыг батлах”, Гэр бүлийн тухай хуулийн 58 дугаар зүйл.</p> <p>Хэрэгжилт: Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 3224 дугаарт бүртгэгдэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.</p>	<p>Эрх зүйн үндэслэл хүчин төгөлдөр хэвээр байгаа бөгөөд Гэр бүлийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.4-д “Гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авсныг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 111 дүгээр зүйлд заасан байгууллага бүртгэнэ” гэж заасан ч Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд дээрх зүйл, заалт байхгүй болно.</p> <p>Байгууллагын даргын 2012 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/619 дүгээр тушаалаар нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд хөдөлгөөн хийгдсэн.</p>	<p>Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан.</p>

2	Гадаадын иргэн, харьяатын газар	2023.12.19	№А/476	Жагсаалт шинэчлэн батлах тухай “Монгол Улсын иргэний харьяаллын асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах бичиг баримтын жагсаалт”-ыг нэгдүгээр, Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргагчийн мэдүүлгийн хуудсыг хоёрдугаар, Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргагчийн мэдүүлгийн хуудсыг загварыг гуравдугаар, Монгол Улсын харьяатаас гарах хүсэлт гаргагчийн мэдүүлгийн хуудсыг дөрөвдүгээр хавсралтаар	6536	<p>Үндэслэл: Харьяатын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 6-д “Монгол Улсын иргэний харьяаллын асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах бичиг баримтын жагсаалтыг гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно”.</p> <p>Хэрэгжилт: Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 6536 дугаарт бүртгэгдэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.</p>	<p>Эрх зүйн үндэслэл хүчин төгөлдөр хэвээр байна.</p> <p>Энэхүү журам нь бусад эрх зүйн зохицуулалттай зөрчилдсөн асуудал үүсээгүй байна.</p> <p>Байгууллагын даргын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/476 дугаар тушаалаар жагсаалтыг шинэчлэн баталсан бөгөөд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд хөдөлгөөн хийгдсэн.</p>	Уг актад өөрчлөлт, хөдөлгөөн хийх шаардлагагүй, цаашид хэвээр мөрдөн ажиллах.
3	Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар	2016.06.10	№А/284	Журам батлах тухай “Гадаадын иргэнд Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилга олгох журмыг нэгдүгээр, Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилгын загварыг хоёрдугаар хавсралтаар”	3648	<p>Үндэслэл: Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.4 дэх хэсэг “гадаадын иргэнд Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилга олгох журмыг батлах”.</p> <p>Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 3648 дугаарт бүртгэгдэн хүчин</p>	<p>Эрх зүйн үндэслэл хүчин төгөлдөр хэвээр байна.</p> <p>Энэхүү журам нь бусад эрх зүйн зохицуулалттай зөрчилдсөн асуудал үүсээгүй байна.</p> <p>Тухайн актын эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд өөрчлөлт хөдөлгөөн хийгдэж байгаагүй болно.</p>	“Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнгийн тайлан, хуулиар тусгайлан эрх олгосон заалтын судалгааны дүн, цаашид авах арга хэмжээний тухай” Засгийн газрын хуралдааны 2023 оны 48 дугаар

						төгөлдөр мөрдөгдөж байна.		тэмдэглэлийг үндэслэн энэхүү 2
4	Гадаадын иргэн, харьяатын газар	2017.03.14	№А/111	<p>Журам батлах тухай</p> <p>“Гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлэх, гарахыг түдгэлзүүлэхийг хүчингүй болгох тухай шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх журам”</p>	3710	<p>Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.3 дахь хэсэг “Гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлэх, гарахыг түдгэлзүүлэхийг хүчингүй болгох тухай шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх журмыг батлах”.</p> <p>Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 3710 дугаарт бүртгэгдэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.</p>	<p>Эрх зүйн үндэслэл хүчин төгөлдөр хэвээр байна.</p> <p>Энэхүү журам нь бусад эрх зүйн зохицуулалттай зөрчилдсөн асуудал үүсээгүй байна.</p> <p>Байгууллагын даргын 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/184 дүгээр тушаалаар нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд хөдөлгөөн хийгдсэн.</p>	<p>журмаар зохицуулсан харилцааг хуульд тусгах, хуулиар эрх олгосон заалтыг хүчингүй болгох хүрээнд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан 2024 оны 01/339 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.</p>

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗАР